

БИЗНЕСИЙН НЭГДЭЛ (ГРУПП КОМПАНИ)-ИЙН ОРЛОГЫН ТАТВАРЫН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Д.Нямаа*, Х.Минжин**

Хураангуй: Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго нь тусдаа бие даан үйл ажиллагаа явуулдаг харилцан хамаарал бүхий толгой, охин компаниудаас бүрдсэн бизнесийн нэгдэл (групп)-ийн санхүүгийн байдал, нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээг нэг аж ахуйн нэгж шигээр толилуулаж тайлагнах явдал байдаг.

Энэхүү өгүүлэлд нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэх хэрэгцээ шаардлага, групп компанийн орлогын татварын тайлагналын өнөөгийн байдал болон нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэх арга зүйн асуудлыг тухайлан судалж, олон улсын хандлагын дагуу Монгол улсад мөрдөж буй хууль, журамд нийцүүлэн үндэсний групп компанийн нэгтгэсэн орлогын татварын тайланг бэлтгэх оролдлого хийж, группын нэгтгэсэн орлогын татварын тайлагналыг боловсронгуй болгон сайжруулах талаар дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Abstract: The objective of the consulted financial statements is to present the financial statements of a group in which the assets, liabilities, equity, income, expenses and cash flows of the parent and its subsidiaries are presented as those of a single economic entity.

In the paper the basis of preparation for consolidated tax report, current status of tax reporting for group companies and methodological issues for tax consolidation are reviewed, moreover the presentation of Consolidated tax report of the Mongolian group company consistence with IFRSs, national legislations and based on global good practice have considered and author's conclusions and recommendations are analyzed.

Түлхүүр үг: Нэгтгэсэн орлогын татварын тайлан, компани хоорондын ажил гүйлгээ, харилцан хамаарал бүхий компани, хэрэгжээгүй олз (гарз), татварын хөнгөлөлт чөлөөлөлт, үнэ шилжилтийн тохируулга

Key words: Consolidated income tax statement, intra-group transactions, affiliates, unearned gains (loss), tax discount and redemption, transfer pricing adjustment

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) anu.nyam@yahoo.com

** Кэй Пи Эм Жи Такс ТМЗ ХХК

Нэгтгэсэн орлогын албан татварын тайлагналын олон улсын практик, давуу тал

Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэх нь³:

- Холбоотой талын татварын тайлангаар тодорхойлогдсон алдагдлыг группын бусад гишүүд татвар ногдуулах орлогоо бууруулах замаар ашиглах боломжтой. Ихэнх нөхцөлд бизнесүүд нэгдэхээс өмнөх группын аливаа гишүүн компанийн тусдаа татварын тайлангаар тодорхойлогдсон алдагдлыг зөвхөн тухайн компанийн ирээдүйд олох татвар ногдуулах орлогыг бууруулах буюу хойшлуулан тооцох зохицуулалтууд байдаг;
- Компани хоорондын ногдол ашгийг татвар ногдуулах орлогод оруулан тооцдоггүй;
- Компани хоорондын ажил гүйлгээнээс үүссэн хэрэгжээгүй олзыг татвар ногдох орлогод оруулан тооцдоггүй бөгөөд тухайн олзыг хэрэгжих хүртэл хойшлуулдаг. (Нөгөө талаар компани хоорондын ажил гүйлгээнээс үүссэн хэрэгжээгүй гарзыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулж тооцдоггүй бөгөөд тухайн гарзыг хэрэгжих хүртэл мөн хойшлуулна);
- Татварын албадын орлогын албан татварын удирдлага хяналтын зардлыг бууруулдаг; мөн
- Группын бүрэлдэхүүн дэх толгой, охин компаниудын орлогын албан татварын тайлан бэлтгэж тайлагнахтай холбоотой зардал, цаг хугацаа, хүндрэлийг бууруулдаг.

Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэдэг группын гишүүн компани тайлант үеийн болон хойшлогдсон орлогын албан татварын зардлаа санхүүгийн тайлагналын зорилгоор санхүүгийн тайландаа толилуулах шаардлага зүй ёсоор үүсдэг. Үүний тулд нэгтгэсэн орлогын албан татварын тайлангаар тодорхойлогдсон орлогын албан татварын зардлыг нэгтгэлийн гишүүн толгой, охин компаниудад хуваарилах дараах аргууд байна⁴:

- Тусдаа орлогын албан татварын тайлангийн арга — Охин компани бүрийн орлогын албан татварын зардлыг нэгтгэлд ороогүй байх үед гарах байсан хэмжээнд үндэслэн хуваарилах;
- Харилцан тохиролцоо арга — группын гишүүд бүр хоорондоо харилцан зөвшилцөх байдлаар гишүүн тус бүрийн орлогын албан татварын хувь хэмжээг тогтоох;
- Оролцооны арга — тухайн группын гишүүнийг нэгтгэлд хамаарахгүй

³ Hoyle, Schaefer, Douppnik, 2017, Advanced Accounting 13th Edition, New-York, the USA.

⁴ Beams, Anthony, Bettinghaus, Smith, 2015, Advanced Accounting 12th Edition, New Jersey, the USA.

байсан бол гарах байсан орлогын албан татварын зардлын хэмжээнд үндэслэж хуваарилах; ба


- Хувь тэнцүүлэн хуваарилах арга — охин компани бүрийн нэгтгэсэн орлогын албан татварын тайлан дах татвар төлөхийн өмнөх орлогын хэмжээнд үндэслэн хуваарилах.

Тусдаа орлогын албан татварын тайлангийн арга болон хувь тэнцүүлэн хуваарилах аргууд нь хамгийн түгээмэл ашиглагддаг байна.

Манай улсын групп компанийн орлогын татварын тайлагналын өнөөгийн байдал, цаашдын хандлага

Группын зохион байгуулалттай үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгааг хийж үзэхэд энэ хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн тоо 2013 оноос хойш эрчимтэй өсөлттэй байна.⁵

График 1. Группын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн тоо, онуудаар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хорооны Бизнес Регистрийн сангийн мэдээлэлд үндэслэсэн судлаачдын тойм

2017 оны байдлаар нийт ААНОАТ татвар төлөгчдийн 4 орчим хувь нь группын бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ТЕГ-аас зарладаг шилдэг татвар төлөгч 100 аж ахуйн нэгжийн УТОХГ-тай харьцдаг дараах 10 татвар төлөгчийн төрийн өмчит хувьцаат компаниудыг эс тооцвол бүгд группын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

⁵ Үндэсний Статистикийн хорооны Бизнес Регистрийн сангийн мэдээлэлд үндэслэсэн тойм

Улсын төсвийн орлого хяналтын газраас тодорхойлсон шилдэг 10 татвар төлөгч:⁶

Хүснэгт 1. Шилдэг татвар төлөгчид

№	Компанийн нэр	Группын зохион байгуулалтай
1	Оюутолгой ХХК	✓
2	Эрдэнэт үйлдвэр ХХК	✓
3	Монгол алт МАК ХХК	✓
4	Цайрт минерал ХХК	✓
5	Мобиком корпораци ХХК	✓
6	Таван толгой ХК	✓
7	Тийсс Монгол ХХК	✓
8	Юнител ХХК	✓
9	Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК	✓
10	Говь ХХК	✓

Эх сурвалж. Улсын төсвийн орлого хяналтын газрын тайлан

Дээрх судалгаанаас үзэхэд улсын төсвийн татварын орлого бүрдэлтэд группын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хувь оролцоо жинтэй нөлөө үзүүлж байгаа тул группын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй компаниуд буюу бизнесийн нэгдлийг эдийн засгийн нэг нэгж болохынх нь хувьд дээрх компаниудад татварын тэгш шударга, үр ашигтай байх үндсэн зарчимтай уялдуулан татварын ногдуулалт, тэр дундаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ногдуулалтыг хийж, тайлагнах нь нэн чухал ач холбогдолтой байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Татварын Ерөнхий Хуулийн 48.4-д “Харилцан хамаарал бүхий этгээд” гэж Монгол Улсын болон гадаад улсын аливаа хуулийн этгээдийн удирдлага, хяналт болон эд хөрөнгийн эрхэд нь шууд ба шууд бусаар оролцох эрхтэй этгээдийг хэлнэ гэж заасан байна. Мөн ААНОАТ тухай хуулийн 6.1-т заасны дагуу Албан татвар төлөгчтэй дор дурдсан харилцаатай бол “харилцан хамаарал бүхий этгээд” гэж үзнэ:

- Энгийн хувьцааных нь 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг;
- Ногдол ашиг, ашгийн хуваарилалтынх нь 20 буюу түүнээс дээш хувийг авах эрхтэй;
- Аж ахуйн нэгжийн удирдлагын 20 буюу түүнээс дээш хувийг томилох

⁶ <http://mta.mn/c/view/40807>

эрхтэй, эсхүл үйл ажиллагааных нь бодлого чиглэлийг тодорхойлдог.

ТЕГ-ын даргын 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/96 тушаалаар баталсан “Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил, үйлчилгээ, бараа гүйлгээний тайлангийн маягт” (маягт ХМХ-01)⁷-ыг баталсан бөгөөд энэ маягтын дагуу 2017 оны жилийн эцсийн татварын тайлангаас эхлэн татвар төлөгчид харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний мэдээллээ татварын албанд тайлагнадаг болсон байна.

Татвар төлөгч Монгол Улсад болон гадаад улсад байгаа харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн борлуулалт, худалдан авалт, боловсон хүчин илгээх, техникийн үйлчилгээ үзүүлэх, хоршсон үйлдвэрлэл явуулах зэрэг үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэ, төлбөр, хураамж нь /цаашид “үнэ” гэх/ бодит үнээс их эсвэл бага байвал татварын ногдлыг тодорхойлохдоо бодит үнийн аргыг хэрэглэнэ.

2015 оны 12 сарын 24-ний өдөр Сангийн Сайдын 353 дугаар тушаалаар *Бодит Үнэ Тооцох Аргачлал*-ыг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү аргачлал батлагдахаас өмнө 2007 оны 4 сарын 4-ний өдөр Сангийн Сайдын 86 дугаар тушаалаар батлагдсан *Жишиг Үнэ Хэрэглэх Аргачлал*-ыг хэрэгжүүлж байсан болно.

Монгол Улс Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх (“BEPS”)–ийн эсрэг байгууллагын 111 дэх гишүүн орноор элссэнтэй холбогдуулан Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын зөвлөмжүүдийг дотоодын хууль тогтоомжинд тусгах шаардлага үүсээд байгаа бөгөөд хоорондоо харилцан хамааралтай талууд буюу бизнесийн нэгдлийн компани хоорондын гүйлгээ, татварын төлөвлөлтийг тухайлан анхаарах шаардлага үүсч байна. Харин манай татварын ерөнхий хууль болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд BEPS-ийн эсрэг болон татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх ерөнхий дүрэм (“GAAR”)–ийн талаарх зохицуулалтуудыг тусгасан байна.

Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэсэн нь

Астра Минералс ХХК нь Канадын хөрөнгө оруулалттай уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани бөгөөд 2007 онд үүсгэн байгуулагдсан. Астра Системс Инженеринг ХХК нь Астра Минералс ХХК-ийн 100% хяналтанд байдаг охин компани нь бөгөөд уул уурхайн туслан гүйцэтгэх, программ хангамж, тооцоо судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм. Бизнесийн нэгдэл дэх дээрх харилцан хамаарал бүхий

⁷ <http://mta.mn/app/f?id=5700&tid=16838>

компаниудын тусдаа санхүүгийн тайлан, ААНОАТ тайлан болон компани хоорондын ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зааварт заагдсан алхамуудаар дараах тооцоолол, тайлагналыг бэлтгэн харууллаа.

1. Нэгтгэгдэх аж ахуйн нэгжийг тодорхойлсон.

Астра Минералс болон Астра Системс Инженеринг компаниуд нь манай улсын компанийн тухай хуулийн дагуу тодорхойлогдсон толгой охин компаниудад хамаарах бөгөөд компанийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд охин компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах ба толгой компани нь охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана гэж заасантай адилаар нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэх боломжтой юм.

Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэхийг зөвшөөрдөг гадаад улс орнуудын жишгээс үзэхэд толгой компанийнхаа 80%-иас дээш хувийн хяналтанд байдаг охин компаниуд толгой компанитайгаа нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэж толилуулах боломжтой байдаг байна.

2. Аж ахуйн нэгжийн тусдаа ААНОАТ-ыг нэгтгэлд бэлтгэсэн.

Хүснэгт 2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан
А. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол:
 /оны эхнээс өссөн дүнгээр төгрөгөөр/

Үзүүлэлтүүд		Мөр	Толгой компани	Охин компани
1. Нийт орлогын дүн (мөр 2+3+4+5+6)		1	2,597,625,844	930,948,778
Үүнээс:	1.2 Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн (Хүснэгт Б, мөр 32+34+39+41+43)	3	25,557,500	1,829,755
	1.4. Бусад орлогын дүн	5	21,890,700	1,530,895
	1.5 Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн (мөр 7+8...+17)	6	2,550,177,644	927,588,128
	Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого	7	2,108,275,459	925,567,838
	Техникийн, удирдлагын зөвлөх болон бусад үйлчилгээний орлого	12	82,500,000	-
	Аавсан хүү, анз /торгууль, алданги/, хохирлын нөхөн төлбөрийн орлого	13	-	1,375,000

Үүнээс:	Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит орлого	14	8,756,350	645,290
	Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн орлого	15	278,000,000	-
	Албан татвар ногдох бусад орлого	17	72,645,835	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		18	1,137,800,905	525,830,900
3. Удирд болон борлуулалтын зардал		19	829,788,469	246,106,878
4. Үндсэн бус үйл ажиллагааны зардал		20		125,000
5. Татварын өмнөх ашиг +, алдагдал- (мөр 1-18-19-20)		21	630,036,470	158,886,001
6. “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гийн А1, В3 мөрийн нийлбэр дүн /татвар төлөхийн өмнөх ашгийг нэмэгдүүлэх дүн/		22	71,590,800	15,308,165
7. “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гийн А2, В4 мөрийн нийлбэр дүн буюу татвар төлөхийн өмнөх ашгийг бууруулах дүн		23	53,425,764	8,790,520
8. Татвар ногдуулах орлогын дүн (мөр 21+22-23)		24	648,201,506	165,403,646
10. Зохицуулагдсан татвар ногдуулах орлогын дүн (мөр 24+25)		26	648,201,506	165,403,646
12. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн (мөр 26-27)		28	648,201,506	165,403,646
13. Ногдуулсан татвар (мөр 28х хуулийн 17.1-д заасан хувиар)		29	64,820,151	16,540,365
14. Хөнгөлөгдөх татварын дүн (маягт ТГ-02(б), Б хүснэгтийн дүн)		30	-	-
15. НИЙТЛЭГ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (мөр 29-30)		31	64,820,151	16,540,365

Эх сурвалж: Толгой ба охин компанийн тусдаа ААНОАТ-ын тайланд үндэслэсэн судлаачийн тойм

Б. Тусгай хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол:

Үзүүлэлтүүд	Мөр	Толгой компани	Охин компани
18. Хүүгийн орлого	39	25,557,500	1,829,755
Хүүд ногдуулсан татвар (мөр 39 х 10%)	40	2,555,750	182,976
21. ТУСГАЙ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАРЫН ДҮН	49	2,555,750	182,976

В. Хуулийн дагуу бусдад суутгуулсан татварын тооцоолол:

Үзүүлэлтүүд	Мөр	Толгой компани	Охин компани
22. Ногдол ашигийн орлого	50	67,500,000	-
Суутгуулсан татвар (мөр 50 х 10 хувь)	51	6,750,000	-
27. ХУУЛИЙН ДАГУУ БУСДАД СУУТГУУЛСАН АЛБАН ТАТВАРЫН ДҮН	60	6,750,000	-

28. НИЙТ ТӨЛБӨЛ ЗОХИХ ТАТВАРЫН ДҮН (Хүснэгт А, мөр 31 + Хүснэгт Б, мөр 49 + Маягт ТТ-13, мөр 24)	61	67,375,901	16,723,340
-----------------------------------------------------------------------------------------------------------------	----	------------	------------

Компани хоорондын ажил гүйлгээ

Хүснэгт 3. Толгой болон охин компани хоорондын ажил гүйлгээ

№	Үзүүлэлт	Нийт	Нийт
1	Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээ	Худалдан авалтын дүн /төгрөг/ 125,800,000	Борлуулалтын дүн / төгрөг/ 950,224,000
2	Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн зээлтэй холбоотой ажил гүйлгээ	Хүлээн авсан зээлийн дүн / төгрөг/-	Олгосон зээлийн дүн /төгрөг/ 896,000,000
3	Харилцан хамааралтай этгээдүүдтэй зардал хуваах, хувиарлах гэрээ / зохицуулалтаар хийсэн ажил гүйлгээ	Хувиарлагдсан зардлын дүн /төгрөг/ 185,753,300	Хүлээгдэж буй өгөөжийн дүн / төгрөг/ 4,552,678

**Харилцан хамааралтай этгээд болох охин
компанитай хийсэн ажил гүйлгээ**

№	Ажил гүйлгээний нэр, төрөл	Худалдан авалтын дүн /төгрөг/	Борлуулалтын дүн /төгрөг/	Ашгийн хувь	Компани хоорондын ашиг /төгрөг/
1	Программ хангамж	125,800,000	589,724,000	16% / 25%	20,128,000 147,431,000
2	Удирдлагын зөвлөх үйлчилгээ		82,500,000	8%	6,600,000
3	Оффисийн түрээс		278,000,000	4%	11,120,000
	Дүн	125,800,000	950,224,000		185,279,000

Эх сурвалж: Харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондох ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тойм

**Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн зээлтэй
холбоотой ажил гүйлгээ**

№	Зээлийн төрөл	Олгосон зээлийн дүн	Зээлийн хүү	Зээлийн төлбөрийн хуваарь	Зээлийн хүүг хуримтлуулах хугацаа
1	Үндсэн хөрөнгийн худалдан авалт	259,500,000	Жилийн 8.5%	Жилийн эцэст 10 жилийн хугацаанд	1 жил
2	Үндсэн үйл ажиллагааны санхүүжилт	636,500,000	Хүүгүй	20x9 оноос эхлэн улирал бүрийн эцэст	
	Дүн	896,000,000	22,057,500		

Эх сурвалж: Харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондох ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэсэн судлаачдын тойм

3. Нэгтгэсэн ААНОАТ тайланд компани хоорондын ажил гүйлгээний нөлөөллийг бүрэн устгах буюу заруулага хийсэн.

Хүснэгт 4. Компани хоорондын гүйлгээний нөлөөллийн устгах бичилт

А. Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол:

Үзүүлэлтүүд	Мөр	Толгой компани	Охин компани	Устгах бичилт		Нэгтгэсэн орлогын албан татварын тайланд томилуулах дүн
				Толгой компани	Охин компани	
1. Нийт орлогын дүн (мөр 2+3+4+5+6)	1	2,597,625,844	930,948,778			3,338,742,945
1.1 Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн (маяг ТТ-02(б), А хэсгийн дүн)	2	-	-			-
1.2 Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн (Хүснэгт Б, мөр 32+34+39+41+43)	3	25,557,500	1,829,755		е (0)	27,387,255
1.4. Бусад орлогын дүн	5	21,890,700	1,530,895		д (4,552,678)	18,868,918
1.5 Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн (мөр 7+8...+17)	6	2,550,177,644	927,588,128			3,292,486,772
Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого	7	2,108,275,459	925,567,838		а (20,128,000) б (147,431,000)	2,866,284,297
Техникийн, удирдлагын зөвлөх болон бусад үйлчилгээний орлого	12	82,500,000	-		в (6,600,000)	75,900,000
Авсан хүү, анз /торгууль, алданги/, хохирлын нөхөн төлбөрийн орлого	13	-	1,375,000			1,375,000
Гадаад валоогын ханшийн зөрүүгийн бодит орлого	14	8,756,350	645,290			9,401,640
Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн орлого	15	78,000,000	-		г (11,120,000)	266,880,000
Албан татвар ногдох бусад орлого	17	72,645,835	-			72,645,835

Үүнээс:

2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	18	1,137,800,905	525,830,900			1,663,631,805
3. Удирдлагын болон борлуулалтын үйл ажиллагааны зардал	19	829,788,469	246,106,878			1,075,895,347
4. Үндсэн бус үйл ажиллагааны зардал	20		125,000			125,000
5. Татварын өмнөх ашиг +, алдагдал-1-18-19-20)	21	630,036,470	158,886,001			599,090,793
6. “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохихуулах тайлан”-гийн А1, В3 мөрийн нийлбэр дүн /татвар төлөхийн өмнөх ашгийг нэмэгдүүлэх дүн/	22	71,590,800	15,308,165			86,898,965
7. “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохихуулах тайлан”-гийн А2, В4 мөрийн нийлбэр дүн буюу татвар төлөхийн өмнөх ашгийг бууруулах дүн	23	53,425,764	8,790,520			62,216,284
8. Татвар ногдуулах орлогын дүн (мөр 21+22-23)	24	648,201,506	165,403,646			623,773,474
10. Зохицуулагдсан татвар ногдуулах орлогын дүн (мөр 24+25)	26	648,201,506	165,403,646			623,773,474
12. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн (мөр 26-27)	28	648,201,506	165,403,646			623,773,474
13. Ногдуулсан татвар (мөр 28х хуулийн 17.1-д заасан хувиар)	29	64,820,151	16,540,365			62,377,347
14. Хөнгөлөгдөх татварын дүн (маяг ТТ-02(6), Б хүснэгтийн дүн)	30	-	-			-
15. НИЙТЛЭГ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (мөр29-30)	31	64,820,151	16,540,365			62,377,347

Б. Тусгай хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол:

Үзүүлэлтүүд	Мөр	Толгой компани	Охин компани	Устгах бичлэг		Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан
				Толгой компани	Охин компани	
18. Хүүгийн орлого	39	25,557,500	1,829,755	е (0)		27,387,255
Хүүд ногдуулан татвар (мөр 39 x 10%)	40	2,555,750	182,976			2,738,726
21. ТУСГАЙ ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАРЫН ДҮН	49	2,555,750	182,976			2,738,726

В. Хуулийн дагуу бусдад суутгуулсан татварын тооцоолол:

Үзүүлэлтүүд	Мөр	Толгой компани	Охин компани	Устгах бичлэг		Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан
				Толгой компани	Охин компани	
22. Ногдол ашгийн орлого	50	67,500,000	-	ж (0)		67,500,000
Ногдол ашигт суутгуулсан татвар	51	6,750,000	-			6,750,000
27. ХУУЛИЙН ДАГУУ БУСДАД СУУТГУУЛСАН АЛБАН ТАТВАРЫН ДҮН	60	6,750,000	-			6,750,000
28. НИЙТ ТӨЛБӨЛ ЗОХИХ ТАТВАРЫН ДҮН (Хүснэгт А, мөр 31 + Хүснэгт Б, мөр 49 + Маягт ТТ-13, мөр 24)	61	67,375,901	16,723,340			65,116,073

Эх сурвалж: Харилцан хамаралтай этгээдүүдийн ААНОАТ-ын тусдаа тайлан болон хоорондох ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэлд чндэслэсэн судлаачдын тооцоолол

Устгах бичилтийн тайлбар:

- А. Охин компанийн Толгой компанидаа хийсэн апстрим программ хангамжийн борлуулалт дах компани хоорондын олзыг устгав: Компани хоорондын апстрим борлуулалтын олз = Борлуулалтын орлого х Ашгийн түвшин $20,128,000 = 125,800,000 \times 16\%$
- Б. Толгой компанийн охин компанид хийсэн даунстрим борлуулалт дах компани хоорондын олзыг устгав:
Компани хоорондын даунстрим борлуулалтын олз = Борлуулалтын орлого х Ашгийн түвшин $147,431,000 = 589,724,000 \times 25\%$
- В. Толгой компанийн охин компанидаа үзүүлсэн удирдлагын зөвлөх үйлчилгээнд хамаарах олзыг устгав:
Удирдлагын зөвлөх үйлчилгээний олз = Үйлчилгээний орлого х Ашгийн түвшин $6,600,000 = 82,500,000 \times 8\%$
- Г. Толгой компанийн охин компанидаа түрээслүүлсэн оффисын түрээстэй холбоотой олзыг устгав:
Түрээсийн үйлчилгээний олз = Түрээсийн орлого х Ашгийн түвшин $11,120,000 = 278,000,000 \times 4\%$
- Д. Толгой компанийн охин компанид хуваарилсан зардалтай холбоотой олзыг устгав Зардал хуваарилалттай холбоотой олз = $4,552,678$
- Е. Хүүний орлого нь ААНОАТ хуулийн заалтын дагуу тусгай хувь хэмжээгээр татвар ногддог орлого тул устгах бичилт хийлгүй үлдээв.
- Ж. Ногдол ашгийн орлого нь ААНОАТ хуулийн заалтын дагуу тусгай хувь хэмжээгээр татвар ногддог орлого бөгөөд группын тухайлсан хөнгөлөлт байхгүй тул устгах бичилт хийлгүй үлдээв.

4. Нэгтгэсэн ААНОАТ зардлын тооцоолол ба хуваарилалтыг хийсэн.

Нийт татварын зардал = $62,377,344$ төгрөг (Нийтлэг хувь хэмжээгээр төлөх татварын тооцоолол)

Оролцооны аргын дагуу нийт татварын зардлыг компани тус бүрт хуваарилбал дараах байдалтай болно. (тухайн группын гишүүнийг нэгтгэлд хамаарахгүй байсан бол гарах байсан орлогын албан татварын зардлын хэмжээнд үндэслэж хуваарилсан):

$$\text{Толгой компани} = 64,820,151 / (64,820,151 + 16,540,365) \times 62,377,344 = 49,696,205$$

$$\text{Охин компани} = 16,540,365 / (64,820,151 + 16,540,365) \times 62,377,344 = 12,681,139$$

Орлогын албан татварын өглөг, зардлыг бүртгэх холбогдох журналын бичилт :

Толгой компанид:

Дт. Орлогын татварын зардал	49,626,205	
Кт. Орлогын татварын өглөг		49,626,205

Охин компанид:

Дт. Орлогын татварын зардал	12,681,139	
Кт. Орлогын татварын өглөг		12,681,139

Тусгай хувь хэмжээгээр төлөх орлогын албан татварын өглөг зардлыг бүртгэх холбогдох журналын бичилт:

Толгой компанид:

Дт. Орлогын татварын зардал	9,350,750	
Кт. Орлогын татварын өглөг		9,350,750

Охин компанид:

Дт. Орлогын татварын зардал	182,976	
Кт. Орлогын татварын өглөг		182,976

5. Үнэ Шилжилтийн Тохируулга бэлтгэсэн.

Энэхүү судалгаанд дурдсанчлан нэгтгэсэн ААНОАТ тайлан бэлтгэсний дараагаар бизнесийн нэгдлүүд компани хоорондын ажил гүйлгээний татварын нөлөөллийн тохируулга буюу үнэ шилжилтийн тохируулга хийх боломжтой. Ингэснээр ирээдүйд татварын шалгалтаар илрэх боломжтой үнэ шилжилттэй холбоотой эрсдлээс зайлсхийх, татварын нөхөн төлбөр, торгууль, алдангиас сэргийлэх боломжтой.

Компани хоорондын ажил гүйлгээтэй холбоотой хийгдэх үнэ шилжилтийн тохируулгууд:

Компани хоорондын хүүгүй санхүүжилт: Толгой компани охин компанидаа үндсэн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулж 636,500,000 төгрөгийг хүүгүй зээлдүүлсэн байна. Ижил төстэй зээлийн хүү жилийн 8.5% байгаад үндэслэн үнэ шилжилттэй холбоотой нэмэлт хүүний орлого, холбогдох татварыг дараах байдлаар тооцоолж болно:

$$\text{Хүүний орлого} = \text{Зээлийн Дүн} \times \text{Жишиг Хүү} = 636,500,000 \times 8.5\% = 54,102,500$$

$$\text{ААНОАТ} = \text{Хүүний орлого} \times 10\% = 54,102,000 \times 10\% = 5,410,250$$

Зардал хуваарилалтын ашигийн түвшин: Толгой компани охин компанидаа хуваарилсан цалин хөдөлмөрийн хөлс, томилолтын зардал ба бүртгэл санхүүгийн зардал зэргээс бусад зардалд хүлээгдэж буй өгөөжийн түвшин тооцоогүй байна. Иймд ижил төстэй зардал хуваарилалтад ашигласан өгөөжийн түвшин болох 2.5%-ийг зардал хуваарилалтын бүхий л нэр төрөлд ашиглаж болох байна. Үүний дагуу тооцоолсон үнэ шилжилтийн тохируулгын дагуух нэмэлт өгөөж болон холбогдох ААНОАТ дараах байдалтай байна.

$$\text{Хүлээгдэж буй өгөөж} = \text{Бусад зардал} \times \text{Жишиг өгөөжийн түвшин} = 7,146,200 \times 2.5\% = 91,155$$

$$\text{ААНОАТ} = \text{Хүлээгдэж буй өгөөж} \times 10\% / 25\% = 91,155 \times 10\% = 9,155$$

6. Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан ба орлогын тайланг бэлтгэх ажлын хүснэгт бэлтгэсэн.

Хүснэгт 5. Групп компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ажлын хүснэгт

Нэгтгэсэн тайланд толилуулах дүн Устгах бичилт Охин компани Толгой компани Үзүүлэлт								
Кредит Дебет								
Орлогын тайлан								
Борлуулалтын орлого	1,620,791,667	805,148,778						2,279,918,560
Толгой компаниас олсон орлого	-	125,800,000		(a) 125,800,000				-
				(б) 589,724,000				
				(в) 82,500,000				
				(г) 278,000,000				
				(д) 190,305,978				
				(е) 22,057,500				
				(ж) 146,021,885				
				(a) 20,128,000		(a)	125,800,000	
				(б) 147,431,000		(б)	589,724,000	1,115,666,805
				(в) 6,600,000		(в)	82,500,000	
				(г) 11,120,000		(г)	278,000,000	
				(д) 4,552,678		(д)	190,305,978	525,429,547
						(е)	22,057,500	
ББӨ	1,137,800,905	525,830,900		(a) 20,128,000		(a)	125,800,000	
				(б) 147,431,000		(б)	589,724,000	1,115,666,805
				(в) 6,600,000		(в)	82,500,000	
				(г) 11,120,000		(г)	278,000,000	
				(д) 4,552,678		(д)	190,305,978	525,429,547
Үйл ажиллагааны зардал (OAT зардал ороогүй)	829,788,469	246,231,878		(д) 4,552,678		(д)	190,305,978	525,429,547

Орлогын татварын зардал	59,001,955	12,864,115	(а) 7,852,189		(а) 7,120,770	78,016,894
			(и)	(н)		
Цэвэр ашиг дах хяналтын хувь оролцоо	<u>756,787,816</u>	<u>146,021,885</u>				<u>560,805,314</u>
Хуримтлагдсан ашгийн тайлан						
Хуримтлагдсан ашиг /Толгой компани/	120,896,790	-				120,896,790
Хуримтлагдсан ашиг /Охин компани/		59,765,380				59,765,380
Ногдол ашиг		67,500,000			ж 67,500,000	-
Хуримтлагдсан ашиг 12/31-нээр	<u>77,684,606</u>	<u>138,287,265</u>				<u>741,467,484</u>
Үзүүлэлт	Толгой компани	Охин компани	Устгах бичлэг		Кредит	Нэгтгэсэн тайланд томилуулах дүн
			Дебет			
Бараа материал	923,670,264	283,670,264			а 20,128,000 б 147,431,000	1,039,781,528
Бусад хөрөнгө	2,356,745,839	594,796,494	7,120,770	ж 276,521,885	в	2,936,390,425
					г	
					д	
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	276,521,885	-				-
Хөрөнгийн дүн	<u>3,556,937,988</u>	<u>878,466,758</u>				<u>3,976,171,953</u>
Орлогын татварын өглөг	137,502,846	13,221,813			и 5,419,405	156,144,064

Бусад өр төлбөр	1,120,874,536	528,957,680		7,852,189 ³	1,657,684,405
Хувьцааг капитал	1,420,876,000	198,000,000	ж	198,000,000	1,420,876,000
Хурямтлагдсан ашиг	877,684,606	138,287,265			741,467,484
Өр төлбөр ба өмчийн дүн	3,556,937,988	878,466,758			3,976,171,953
				1,835,512,635	1,835,512,635
					-

Эх сурвалж: Харицан хамааралтай этгээдүүдийн тусдаа санхүүгийн тайлан, хоорондын ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэсэн судлаачдын тооцоолол

Устгах бичилтийн тайлбар:

- А.** Охин компанийн толгой компанидаа хийсэн апстрим программ хангамжийн борлуулалт, ББӨ болон компани хоорондын олзыг устгаж бичив:
- | | |
|-------------------------|-------------|
| Дт. Борлуулалтын орлого | 125,800,000 |
| Кт. ББӨ | 125,800,000 |
| Дт. ББӨ | 20,128,000 |
| Кт. Бараа материал | 20,128,000 |
- Б.** Толгой компанийн охин компанидаа хийсэн даунстрим борлуулалт, ББӨ болон компани хоорондын олзыг устгав:
- | | |
|-------------------------|-------------|
| Дт. Борлуулалтын орлого | 589,724,000 |
| Кт. ББӨ | 589,724,000 |
| Дт. ББӨ | 147,431,000 |
| Кт. Бараа материал | 147,341,000 |
- В.** Толгой компанийн охин компанидаа үзүүлсэн удирдлагын зөвлөх үйлчилгээнд хамаарах борлуулалтын орлого, охин компанийн үйл ажиллагааны зардал, толгой компанийн олзыг устгав:
- | | |
|-------------------------|------------|
| Дт. Борлуулалтын орлого | 82,500,000 |
| Кт. ҮАЭ | 82,500,000 |
| Дт. ҮАЭ | 6,600,000 |
| Кт. Дансны авлага | 6,600,000 |
- Г.** Толгой компанийн охин компанид түрээслүүлсэн оффисын түрээстэй холбоотой орлого, түрээсийн зардлыг устгав:
- | | |
|-------------------------|-------------|
| Дт. Борлуулалтын орлого | 278,000,000 |
| Кт. ҮАЭ | 278,000,000 |
| Дт. ҮАЭ | 11,120,000 |
| Кт. Дансны авлага | 11,120,000 |
- Д.** Толгой компанийн охин компанидаа хуваарилсан зардалтай холбоотой олзыг устгав:
- | | |
|-------------------------|-------------|
| Дт. Борлуулалтын орлого | 190,305,978 |
| Кт. ҮАЭ | 190,305,978 |
| Дт. ҮАЭ | 4,552,678 |
| Кт. Дансны авлага | 4,552,678 |
- Е.** Толгой компанийн охин компанид олгосон зээлтэй холбоотой хүүний орлого зардлыг устгав:
- | | |
|-------------------|------------|
| Дт. Хүүний орлого | 22,057,500 |
| Кт. Хүүний зардал | 22,057,500 |
- Ж.** Хөрөнгө оруулалтын орлого, ногдол ашиг, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт дансыг тайлант үеийн эхний үлдэгдэл рүү тохируулав.
- | | |
|----------------------|-------------|
| Дт. Хувьцаат капитал | 198,000,000 |
|----------------------|-------------|

Дт. Охин компаниас олсон орлого	146,021,885
Кт. Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	276,521,885
Кт. Ногдол ашиг	67,500,000

З. Компани хоорондын хөрөнгө оруулалтаар охин компанийн цэвэр ашгаас толгой компанид оногдох хэсэгт ноогдох татвар

Зарлаж хүлээж авсан ногдол ашигт хамаарах орлогын албан татварын зардлыг тайлант үеийн зардлаар, охин компанийн хуваарилагдаагүй үлдсэн цэвэр ашгийн дүнд хамаарах татварыг хойшлогдсон татварын өглөгөөр тусгав.

Дт. Орлогын татварын зардал	14,602,189
Кт. Хойшлогдсон татварын өглөг	7,852,189
Кт. Орлогын татварын өглөг	6,750,000

/Хуваарилсан ногдол ашигтай холбоотой орлогын татварын өглөгийг өмнө тайлагнасан тул хуваарилагдаагүй үлдсэн ногдол ашигтай холбоотой орлогын татварын бичилтийг хийв/.

И. Үнэ шилжилтийн тохируулгатай холбоотой татварын зардлыг бүртгэв

Дт. Орлогын татварын зардал	5,419,405
Кт. Орлогын татварын өглөг	5,419,405

Нэмэлт тайлбар: Нэгтгэсэн орлогын албан татварын тайланг бэлтгэхдээ компани хоорондын бараа, ажил, үйлчилгээний апстрим болон даунстрим борлуулалттай холбоотой олзыг татвар ногдох орлогод оруулан тооцохгүй гэсэн нөхцөлтэйгээр бэлдсэн тул нэгтгэсэн санхүүгийн болон татварын тайлан хооронд аливаа зөрцү үүсэхгүй. Иймд компани хоорондын ажил гүйлгээнд хамаарах олзтой холбоотой хойшлогдсон татварын тохируулах бичилт хийгээгүй болно. Эсрэг нөхцөлд:

К. Компани хоорондын борлуулалтын ажил гүйлгээний олз:

Дт. Хойшлогдсон татварын хөрөнгө	16,755,900
Кт. Орлогын татварын зардал	16,755,900

гэсэн бичилтийг хийх боломжтой.

Л. Компани тус бүрийн хойшлогдсон татварын хөрөнгийг нэгтгэн бүртгэв:

Дт. Хойшлогдсон татварын хөрөнгө	7,120,770
Кт. Орлогын татварын зардал	7,120,770

Дүгнэлт

Манай улсад одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ААНОАТ тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж бүр тусдаа ААНОАТ тайлан бэлтгэж байгаа хэдий ч сүүлийн үед татварын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цаашдын шинэчлэлийн хүрээнд бизнесийн нэгдлийн орлогын албан татвар, тэр дундаа компани хоорондын ажил гүйлгээтэй холбоотой үнэ шилжилтийн талаарх асуудалд ихээхэн ач холбогдол өгч байна. Одоогийн байдлаар бизнесийн нэгдлүүдийн хувьд үнэ шилжилтийн тохируулга бэлтгэх нарийвчилсан заавар зөвлөмж үгүй, зөвхөн ерөнхий зохицуулалт манай улсын татварын хууль тогтоомжид тусгагдсан байгаа нь татвар төлөгчдөд компани хоорондын ажил гүйлгээний бодит үнийг тодорхойлох, харьцуулагдах байдлын шинжилгээ хийхэд тодорхой бус байдлыг үүсгээд байгаа юм.

Бид судалгааны ажлаараа групп компаниудын хувьд бизнесийн нэгдлийн орлогын албан татварын оновчтой бүртгэл, тайлагнал нь удирдлагын шийдвэр гаргалт, татварын төлөвлөлтийн бодит үндэс суурь болно гэдгийг судлан тогтоосон ба дэлхий нийтийн чиг хандлага, олон улсын татварын гол анхаарал татаж буй асуудалд ч BEPS (Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх), GAAR (Татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх ерөнхий дүрэм) зэрэг бизнесийн нэгдлүүдийн татварын төлөвлөлтийн арга хэрэгслүүд багтаж байгаа юм.

Дэлхийн улс орнуудын практикаас харахад групп компаниудад компани хоорондын ажил гүйлгээтэй холбоотойгоор татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлдэг, мөн нэгтгэсэн орлогын татварын тайлан бэлтгэх боломжоор хангадаг байдал хэвшил болсон байгаа ба Монгол улсын төсвийн татварын орлого, тэр дундаа ААНОАТ орлого бүрдэлтэд тэргүүлэх байр суурийг эзэлж байгаа групп компаниудын хувьд компани хоорондын ажил гүйлгээтэй холбоотойгоор үүсэх татварын аливаа эрсдэл болон нөлөөллийг бодитойгоор тодорхойлж, түүний нөлөөллийг нэгтгэсэн санхүүгийн тайландаа толилуулах нь нэн чухал ач холбогдолтой.

Бизнесийн нэгдлийн орлогын албан татвар, бүртгэл тайлагналыг боловсронгуй болгон сайжруулах асуудлын хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна:

1. Бизнесийн нэгдлүүд нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Татварын төлөвлөлтийг оновчтой болгох, татварын ногдуулалтыг тэгш шударга, үр ашигтай байх үндсэн зарчимтай нь уялдуулахын тулд бизнесийн нэгдлийн нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэх боломжтой. Нэгтгэсэн орлогын албан татварын тайлан бэлтгэснээр дараах ач

холбогдолтой байна:

- Макро түвшинд татварын ногдуулалт тэгш шударга, үр ашигтай байх үндсэн зарчимтайгаа уялдах, татварын албадын орлогын албан татварын удирдлага хяналтын зардал буурах;
 - Микро түвшинд бизнесийн нэгдлүүд ААНОАТ ногдлоо тодорхойлохдоо холбоотой талын татварын тайлангаар тодорхойлогдсон алдагдлыг группын бусад гишүүд татвар ногдуулах орлогоо бууруулах замаар ашиглах, компани хоорондын ногдол ашгийг татвар ногдуулах орлогод оруулан тооцохгүй байх; компани хоорондын ажил гүйлгээнээс үүдэлтэй хэрэгжээгүй олзыг татвар ногдох орлогод оруулан тооцолгүй олзыг хэрэгжих хүртэл хойшлуулах, орлогын албан татварын тайлан бэлтгэж тайлагнахтай холбоотой зардал, хүндрэлийг бууруулах, мөн татварын төлөвлөлтийг оновчтой илүү цогц хэлбэрээр хийх боломжтой юм.
2. Холбоотой талын ажил гүйлгээнд үнэ шилжилтийн тохируулгыг судалгаанд санал болгосон загварын дагуу бэлтгэж тайлагнах. Үүний дүнд бизнесийн нэгдлүүд ирээдүйд хийгдэх татварын шалгалтаар илэрч болзошгүй үнэ шилжилттэй холбоотой эрсдлээс зайлсхийх, үүнтэй холбогдох татварын нөхөн төлбөр, торгууль, алдангиас сэргийлэх боломжтой юм.
 3. Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан ба орлогын тайланг бэлтгэх, холбогдох ажлын хүснэгтийг бэлтгэх хүрээнд орлогын албан татварын нөлөөллийг нягтлан бодох бүртгэлд тусгаж бүртгэдэг болох . Ингэснээр орлогын албан татварын нөлөөллийг нэгтгэсэн санхүүгийн тайланд багцлан тодорхойлж мэдээлэл хэрэглэгчдэд хүргэх боломжтой юм.

Ашигласан материал

- [1] Алтанзаяа, Г. 2016, *Татварын бүртгэл*, Улаанбаатар, Монгол.
- [2] Бямбахишиг, Д. 2017, *Нэгтгэсэн санхүүгийн тайлагнал дахь орлогын албан татварын нөлөөллийн зарим асуудал*, Улаанбаатар, Монгол.
- [3] Монгол Улсын Үндэсний Статистикийн газар, 2000-2017, *Монгол Улсын Статистикийн эмхэтгэл*, Улаанбаатар, Монгол.
- [4] Нямаа, Д. 2015, *Санхүүгийн Тайлагналын Онол, Арга Зүйн Зарим Асуудал*, Улаанбаатар, Монгол.
- [5] МҮХАҮТ, 2016, *Зарим аж ахуйн нэгжүүдийн татвар төлөлт, үйл ажиллагаа эрхэлж буй газрын судалгаа*.
- [6] Нямаа. Д. 2017, *Бизнесийн нэгдлийн нэгтгэсэн санхүүгийн*

- тайлагналын арга зүй, Улаанбаатар , Монгол
- [7] Beams, Anthony, Bettinghaus, Smith, 2015, *Advanced Accounting 12th Edition*, New Jersey, the USA.
- [8] Hoyle, Schaefer, Douppnik, 2017, *Advanced Accounting 13th Edition*, New-York, the USA.
- [9] Бизнесийн нэгдэл дэх дээрх харилцан хамаарал бүхий компаниудын 2017 оны 12-р сарын 31-ээрх тусдаа санхүүгийн тайлан, ААНОАТ тайлан болон компани хоорондын ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл
- [10] Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль (2006/06/29)
- [11] Компанийн тухай хууль (2011/10/06)
- [13] Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015/06/19)
- [14] Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2015/07/09)
- [15] Сангийн Сайдын 2015 оны 353 дугаар тушаал, *Бодит цнэ тооцох аргачлал*.
- [16] Сангийн Сайдын 2015 оны 170 дугаар тушаал, *Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх заавар*.
- [17] Сангийн Сайдын 2010 оны 121 дүгээр тушаал, *Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрцөг зохицуулах журам*,
- [18] СТОУС-3 Бизнесийн нэгдэл
- [19] СТОУС-10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан
- [20] ТЕГ-ын даргын 2017 оны А/96 тушаал, *Харилцан хамаарал бүхий этгээдцүдийн хооронд хийгдсэн ажил, үйлчилгээ, бараа гүйлгээний тайлангийн маягт (маягт ХМХ-01)*.
- [21] Татварын ерөнхий хууль (2008/05/20)
- [22] <http://www.bdsec.mn/>
- [23] <https://www.economist.com/news/briefing/21715653-biggest-business-idea-past-three-decades-deep-trouble-retreat-global>
- [24] https://en.wikipedia.org/wiki/Tax_consolidation
- [25] <https://www.iltod.gov.mn>
- [26] <http://mta.mn/app/f?id=5700&tid=16838>
- [27] <http://www.mta.mn/app/f?id=4005&tid=12193>
- [28] <http://mta.mn/c/view/40807>